

БАТЛАВ:

“ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ”
ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР
БАРАА ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН
БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр:

VPN, OPGW сүлжээ үүссэн дэд
станцуудын тоолуурын мэдээллийг
тус сувгаар дамжуулан авах

Тендер шалгаруулалтын дугаар:

ДҮТ/20240202003

2024 он

САНАМЖ

Тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер нь захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний гол нөхцөл болох тул тендер шалгаруулалт зохион байгуулах, түүнд оролцохын өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнийг даган батлагдсан журам, заавар, дүрэм, гэрээний нөхцөл, тендер шалгаруулалтын жишиг баримт бичигтэй сайтар танилцахыг зөвлөж байна.

Захиалагч нь тендер шалгаруулалт зохион байгуулахад худалдан авах ажиллагааны үндсэн зарчмууд болох өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, хариуцлагатай, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг баримтална.

Энэхүү харьцуулалтын аргын тендер шалгаруулалтын баримт бичиг нь тендер шалгаруулалтын зааварчилгаа, өгөгдлийн хүснэгт, техникийн тодорхойлолтын шаардлага, тендерийн жишиг маягт, гэрээний нөхцөл гэсэн бүлэгтэй.

Тендер шалгаруулалтын зааварчилгаа (цаашид “ТШЗ” гэх) бүлгийн зүйл, заалтыг нэмж, эсхүл өөрчилж үл болох бөгөөд захиалагч, оролцогч-сонирхогч этгээд нь тэдгээрийг баримтална. Захиалагч тендерийн баримт бичгийг боловсруулахаа ТШЗ-нд үндэслэн, худалдан авах барааны онцлогийг харгалзан өгөгдлийн хүснэгт (ӨХ)-ийг боловсруулах ба шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд өөрчлөлт оруулсан бол өөрчлөлтөд нийцүүлэн бэлтгэнэ.

Техникийн тодорхойлолт бүлэгт захиалагчийн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой хэрэгцээ, шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгасан байна.

Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд үндэслэн жишиг маягтуудын хаалт дотор налуугаар бичсэн тохирох мэдээллийг зааварт нийцүүлэн бүрэн, үнэн зөв бөглөж ирүүлнэ. Гэрээний нөхцөл бүлэг нь захиалагч, шалгарсан оролцогчийн хооронд байгуулагдах гэрээний зүйл, заалтууд тул талууд үүнийг судалсан байвал зохино.

Харьцуулалтын аргын тендер шалгаруулалтын анхаарах асуудлууд:

- ❖ Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээ /Бараа цахим каталогт бүртгэгдсэн байна./
- ❖ Тендер шалгаруулалтын зарлал нийтэлж, бүртгэлтэй аж ахуй эрхлэгчид урилга хүргүүлж, үнийн санал дуудна. Тендер шалгаруулалтын баримт бичгийг цахим систем [/www.tender.gov.mn/-д нийтэлнэ](http://www.tender.gov.mn/-д нийтэлнэ).
- ❖ Үнийн саналыг дуудах хугацаа нь урилга хүргүүлсэн, зарлал нийтэлсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй өдрийн дараа байхаар тогтоосон байна.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдэд цахим системээс ялгах дугаар олгоно.
- ❖ Заасан хугацаанд сонирхогч этгээд тендерийг цахим системд ирүүлнэ.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагааг 2 хүртэл цагийн хугацаагаар зохион байгуулна. Уг хугацааны дотор саналыг бууруулан хэдэн ч удаа ирүүлж болно.
- ❖ Үнийн санал дуудах ажиллагаа хаагдахад өсөх дарааллаар эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийг тодорхойлно.
- ❖ Эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендерийг хянан үзэж, шаардлага хангасан бол гэрээ байгуулах эрх олгоно.

Эхэнд эрэмбэлэгдсэн үнийн санал бүхий оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА.....	4
II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ	11
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	16
IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ	21
V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ	24

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- | | |
|---|---|
| 1. Тендерийн цар хүрээ | 1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "Хууль" гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгт (цаашид "ӨХ" гэх)-д заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон бараа, түүний дагалдах үйлчилгээ (цаашид "бараа" гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтын баримт бичгийг гаргаж байна. Зарлалын дугаар, тендер шалгаруулалтын нэр, дугаар, багцын мэдээлэл өгөгдлийн хүснэгтэд бичигдэнэ. |
| 2. Санхүүжилтийн үүсвэр | 2.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр, төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана. |
| 3. Худалдан ажиллагааны тогтоомж | 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрднө. |
| 4. Оролцогч, сонирхогч этгээдэд тавигдах ерөнхий шаардлага | 3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрднө.
3.2. Худалдан авах ажиллагаанд захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.
3.3. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20 ¹ , 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй. |
| 5. Туслан гүйцэтгэгч | 4.1. Оролцогч хуулийн 7.1.1-7.1.9-д заасан нөхцөлийг хангасан байна.
4.2. Түншлэлээр оролцох тохиолдолд түншлэлийн гишүүн бүр ерөнхий шаардлага хангасан байна.
4.3.. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.
4.4. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
4.5. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
5.1. Хуулийн 6.4-т зааснаар тендерийн үнийн 20 хүртэл хувьтай тэнцэх гүйцэтгэлийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэх тохиолдолд туслан гүйцэтгэх үүргийг гэрээнд заасан байна.
5.2. Туслан гүйцэтгүүлэх хувь хэмжээ тендерийн үнийн 20 хувиас хэтэрсэн, эсхүл туслан гүйцэтгүүлэх тоо хэмжээг заагаагүй бол туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
5.3. Туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна. |

6.Бараанд тавигдах ерөнхий шаардлага		6.1.Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан бараа худалдан авахаас, эсхүл хууль тогтоомжоор барааны гарал үүслийг заавал нотлохоос бусад тохиолдолд оролцогч аль ч улсын гарал үүсэлтэй бараа санал болгож болно. 6.2.Харьцуулалтын аргаар худалдан авах бараа Сангийн сайдын баталсан “Бүртгэл хөтлөх, мэдээллийг баталгаажуулах журам”-ын дагуу хуулийн 4.1.25-д заасан цахим каталогид бүртгэгдсэн байна.
7.Худалдан ажиллагааны систем	авах цахим	7.1.Харьцуулалтын аргаар ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.
		Б.АГУУЛГА
8.Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл		8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг дараах бүлэг болон түүний нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ. I Бүлэг. Тендер шалгаруулалтын заavarчилгаа; II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт; III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага, бараа нийлүүлэлтийн хуваарь; IV Бүлэг. Тендерийн жишиг маягт; V Бүлэг. Гэрээний нөхцөл. 8.2.Тендер шалгаруулалтын зарлал, цахим системээр хүргүүлсэн урилга нь тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрдэл болохгүй. 8.3.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон тэдгээрт иш татсан хууль, журам, зааврыг судалж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.
9.Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах		9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно. 9.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна. 9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана. 9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн тооцно. 9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 10-д заасныг мөрдөнө.
10.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах		10.1.Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. 10.2.Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

- 11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**
- 10.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.
- 11.1. Захиалагч сонирхогч этгээдийн тендер бэлтгэхтэй холбоотой асуултад хариулт өгөх уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол өгөгдлийн хүснэгтэд заана.
- 11.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно.
- 11.3. Уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

- 12. Тендер шалгаруулалтын хэл**
- 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.
- 12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т заасан тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.
- 12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.
- 13. Тендерийн бүрдэл**
- 13.1. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
- 13.1.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
 - 13.1.2. Тендерийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
 - 13.1.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
 - 13.1.4. ТШЗ-ны 16-т заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
 - 13.1.5. Бараа нийлүүлэлтийн хуваарь;
 - 13.1.6. Санал болгож буй бараа ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
 - 13.1.7. ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

		13.1.8.ТШЗ-ны 22.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
		13.2.Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
14.Тендерийн жишиг маягт		14.1.IV бүлэг дэх маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.
15.Хувилбарт санал		15.1. Хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг ирүүлэх шаардлагатай бол өгөгдлийн хүснэгтэд заана.
16.Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг		16.1.ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1. 16.2.Хэрэв өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 7.1-д заасан ерөнхий нөхцөлийг магадлахтай холбоотой баримт бичиг. 16.3.Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.
17.Чадавхын болон туршлагын шаардлага тавих үндэслэл		17.1.ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тавихад хуулийн 15 дугаар зүйлийг баримтална. 17.2.Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй. 17.3.Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.. 17.4.Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
18.Санхүүгийн чадавхын шаардлага		18.1.Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна. 18.2.Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана. 18.3.Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй. 18.4.Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
19.Техникийн чадавх болон туршлагын шаардлага		19.1.Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна. 19.2.Техникийн болон туршлагын чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах бол хуулийн 17.2-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

	19.3.Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.
20.Санал болгож буй бараанд тавигдах шаардлага	<p>20.1.TШЗ-ны 6.1-д заасан тохиолдолд импортын барааны гарал үүслийг нотлох баримт бичиг тендерт ирүүлэхийг шаардахгүй.</p> <p>20.2.Санал болгож буй барааны техникийн тодорхойлолтод нийцсэн болохыг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.</p> <p>20.3.Нотлох баримт нь нийтлэл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас хэлбэрээр байж болно.</p> <p>20.4.Хэрэв санал болгох бараа техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй боловч шаардлага хангах бол түүнийг нотлох шаардлагатай.</p> <p>21.1.Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээний холбоотой өгөгдлийн хүснэгтэд заасан бол дараах баримт бичиг, мэдээллийг ирүүлнэ. Үнд:</p> <p>21.1.1.санал болгож буй барааг тасралтгүй, горимын дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан хугацаанд ашиглахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт, авах боломжтой хаяг, тэдгээрийн үнийн мэдээлэл;</p> <p>21.1.2.засвар, үйлчилгээг хэрхэн үзүүлэх тухай баримт болон мэдээлэл.</p> <p>21.1.3.гадаадын этгээдийн хувьд нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээг үзүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрөө, эсхүл өөрийн Монгол Улсад байгуулсан буюу байгуулах салбар, төлөөний газар, эсхүл бусад төлөөлөгч гүйцэтгэх тухай баримт.</p>
21.Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээ	<p>22.1.Унийн санал дуудах ажиллагаа хаагдахад санал болгосон үнэ оролцогчийн тендерийн үнэ байна.</p> <p>22.2.Тендерийн үнэ гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх эсэхийг өгөгдлийн хүснэгтэд заана. Өгөгдлийн хүснэгтэд тогтмол байхаар заасан тохиолдолд тохируулга хийх нөхцөлтэй тендер ирүүлсэн бол шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцуу гэж үзнэ.</p> <p>22.3.Бараа нийлүүлэх тендерт Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргадаг Олон улсын худалдааны нөхцөл /Incoterms/-ийг хэрэглэхдээ өгөгдлийн хүснэгтэд заагаагүй бол хамгийн сүүлийн хувилбарын Delivery Duty Paid /DDP/ нөхцөлийг бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.</p> <p>22.4.Унийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.</p> <p>22.5.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь бараа, ажил, үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.</p>
22.Тендерийн үнэ	

23.Тендерийн валют	23.1.Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлнэ.
24.Тендер хүчинтэй байх хугацаа	<p>24.1.Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээнээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.</p> <p>24.2.Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 24.1-д заасан хугацааг сунгаж болно.</p> <p>24.3.Оролцогч хугацааг сунгасан бол хуулийн 28.9-д зааснаар бичгээр мэдэгдэнэ.</p>
	Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ
25.Тендер баталгаажуулах, илгээх	<p>25.1.Тендерийг хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулан илгээнэ.</p> <p>25.2.Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол IV бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.</p> <p>25.3.Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг IV бүлгийн Маягт 5-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p> <p>25.4.Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.3-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэлд хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.</p>
26.Тендер хүлээн авах эцсийн хугацаа	26.1.Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
	Д.ҮНИЙН САНАЛ ДУУДАХ АЖИЛЛАГАА
27.Үнийн санал дуудах хугацаа	<p>27.1.Хуулийн 34.6-д зааснаар үнийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлсэн сонирхогч этгээдийн тоо зарлалд заасан шаардлагатай тоонд хүрсэн тохиолдолд уг ажиллагаа ТШЗ-ны 26.1-д товлосон хугацаанаас нэг цагийн дотор эхэнлнэ.</p> <p>27.2.Үнийн санал дуудах ажиллагаа хуулийн 34 дүгээр зүйлд заасан журмын дагуу явагдана.</p> <p>27.3.ТШЗ-ны 27.2-т заасан ажиллагаа урилгад заасан хугацаанд үргэлжилж хаагдана.</p>
28.Тендер нээх	28.1.ТШЗ-ны 27.3-т зааснаар хугацаа хаагдахад цахим систем оролцогч нарын санал болгосон эцсийн үнийг есөх дарааллаар эрэмбэлэх ба захиалагч зөвхөн эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендерийг нээнэ.

Е.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ /ХЯНАН ҮЗЭХ

29.Тендерийг шаардлагад нийцэх эсэхийг хянан үзэх	29.1.Нээсэн тендерийг хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн бурдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн Сангийн сайдын баталсан зааврын дагуу хянан үзнэ. 29.2.Тендерт ирүүлсэн аливаа баримт бичгийн үнэн зөв, хүчинтэй байдлыг шалгаж үзэх эрхтэй байна. 29.3.Эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн тендер шаардлагад нийцээгүй бол удаах эрэмбэлэгдсэн тендерийг хянан үзнэ.
30.Тендерийн талаар тодруулга авах	30.1.Тендерийг хянан үзэх явцад тодруулга авах шаардлагатай гэж үзвэл хуулийн 25 дугаар зүйлийг баримтална.

Ё.МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

31.Мэдэгдэл хүргүүлэх	31.1.Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
32.Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах	32.1.Захиалагч ТШЗ-ны 8.1-д заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ. 32.2.Шалгарсан оролцогч ТШЗ-ны 32.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчийн тогтоосон хугацааны дотор хүргүүлнэ. 32.3.Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

Ж.БУСАД

33.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлах	33.1.Захиалагч ТШЗ-ны 29.3-т зааснаар хянан үзээд бүх тендерээс татгалзсан бол шаардлага хангасан тендер ирээгүй шалтгааныг судалж, тендер шалгаруулалтыг дахин зарлах эсэх мэдээллийг хуулийн 28.1.3-т заасан шийдвэрт заана. 33.2.Үнийн санал дуудах ажиллагааг дахин зарлахад хуулийн 34.11-д заасныг баримтална.
34.Тендер шалгаруулалтад гомдол гаргах	34.1.Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

II БҮЛЭГ.ӨГӨГДЛИЙН ХУСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	<p>Захиалагчийн нэр: “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК Зарлалын дугаар: ДҮТ/20240202003 Тендер шалгаруулалтын нэр: VPN, OPGW сүлжээ үүссэн дэд станцуудын мэдээллийг тус сувгаар дамжуулан авах Тендер шалгаруулалтын багцын тоо болон нэр: Багцгүй.</p>
ТШЗ 2.1	<p>Санхүүжилтийн эх үүсвэр: Өөрийн хөрөнгө Нийт төсөвт өртөг: 37,165,030 (гучин долоон сая нэг зуун жаран таван мянга гуч) төгрөг</p>
Б.АГУУЛГА	
ТШЗ 9.2	<p>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хариуцсан ажилтан: Мэдээлэл холбоо, электроникийн инженер М.Энхбаясгалан Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын 14-р байр, 4, 5 давхар Утасны дугаар: 70043467, 70041371-289 /ажлын цагаар 08:00-17:00/ Цахим шуудан: enkhbayasgalan.m@ndc.energy.mn</p> <p>Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоног байна. Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд цахим систем дэх тендерийн урилгын тодруулга, мэдээллийг байнга шалгахыг зөвлөж байна.</p>
ТШЗ 11.1	<p>Тендер ирүүлэх өмнө уулзалт зохион байгуулах эсэх: Үзүй</p>
В.ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.2	<p>Тендер шалгаруулалтын хэл:</p> <p>Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, тендерт оролцогчдын ирүүлэх тендер Монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг зохих ёсоор орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.</p> <p>Тендерийн материалыг Монгол хэл дээр ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТШЗ 12.4	<p>Захиалагч ТШЗ-ны 12.2-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран орчуулга үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.</p>
ТШЗ 15.1	<p>Хувилбарт санал ирүүлэхийг: Зөвшөөрөхгүй</p>
ТШЗ 16.2	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> 1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ. 2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 3. Тендер нээсэн өдрийн байдлаар Монгол Улсын хуулийн дагуу хугацаа хэтэрсэн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй байх шаардлагатай.



	<p>Жич: Татвар болон нийгмийн даатгалын тодорхойлолтыг тендерийн баримт бичигт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” (www.tender.gov.mn)-ээр дамжуулан шалгана.</p> <p>4. Монгол Улсын хуулийн этгээд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа эсэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолтыг ирүүлнэ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Жич: Дээрх тодорхойлолтыг авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу.</p> <p>Хэрэв дээрх тодорхойлолтыг цахим системээр ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: Шаардана</p> <ol style="list-style-type: none"> Борлуулалтын орлогын хэмжээ: 2022, 2023 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлого нь тендерт оролцогчийн санал болгож буй үнийн дүнгийн 100 хувиас багагүй байна. Тендерт оролцогч нь 2022, 2023 он тус бүрт ашигтай ажилласан байна.
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: Тийм</p> <ol style="list-style-type: none"> Оролцогчийн 2022, 2023 онуудын санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдэж, баталгаажсан байх шаардлагатай. Санхүүгийн тайлан цахим бүртгэлд шивэгдэж, баталгаажаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Тендерийн батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно. Үүнд: <ol style="list-style-type: none"> Байгууллагын харилцагч банкин дахь харилцах дансны үлдэгдлийн баталгаа; Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт; Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд; Банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй байна. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн” бус

	<p>байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. Оролцогч “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна.</p> <p>Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалzan үзэхгүй.</p> <p>Жич: 2022, 2023 онуудын санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр дамжуулан тендерт оролцогчдын баталгаажсан санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана.</p>																														
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлага: Шаардана. ТШЗ 19.2 дох хэсгийн 1-9, 14 шаардлагуудыг хангасан байна.</p> <p>Ижил төстэй гэрээний туршлага: Шаардана. ТШЗ 19.2 дох хэсгийн 10, 11, 12,13 шаардлагуудыг хангасан байна.</p> <p>Гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын шаардлага: Шаардана.</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th><th>Албан тушаал</th><th>Хүний тоо</th><th>Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага</th><th>Мэргэжил</th><th>Диплом, гэрчилгээний хуулбар ирүүлэх шаардлагатай эсэх</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td>Ерөнхий инженер</td><td>1</td><td>3 болон түүнээс дээш жил.</td><td>Цахилгааны болон мэдээлэл технологийн чиглэлийн инженер</td><td>Диплом ирүүлэх шаардлагагүй</td></tr> <tr> <td>2</td><td>Мэдээлэл технологийн чиглэлийн инженер</td><td>1</td><td>2 болон түүнээс дээш жил</td><td>Мэдээлэл технологийн чиглэлийн инженер</td><td>Диплом ирүүлэх шаардлагагүй.</td></tr> <tr> <td>3</td><td>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан</td><td>1</td><td>1 болон түүнээс дээш жил</td><td>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан гэрчилгээтэй байна</td><td>Сургалтад хамрагдсан гэрчилгээ ирүүлнэ.</td></tr> <tr> <td>4</td><td>Ажил гүйцэтгэхэд шаардлагатай бусад инженер</td><td>2</td><td></td><td>Ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн ажиллах хүчин байна. Заавал байх шаардлагагүй.</td><td>Ажил гүйцэтгэхэд чиглэгдсэн мэргэжилтэй байх</td></tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> - Дээрх инженер, техникийн ажилтнуудын жагсаалтыг гаргаж, тухайн төсөл арга хэмжээнд ажиллуулахаар томилсон байх бөгөөд тэдгээрийн ажлын туршлагыг ажилтан тус бүрээр гаргаж ирүүлнэ. - Дээрх инженер, техникийн ажилтнуудын иргэний үнэмлэх, аюулгүй ажиллагааны мэргэшлийн үнэмлэхийн хуулбарыг ирүүлэх ба үнэмлэхийн хугацаа хүчин төгөлдөр байна. Сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагатай. - Хэрэв инженер, техникийн ажилтнууд нь гэрээгээр ажиллах бол хөлсөөр ажиллах гэрээ, иргэний үнэмлэхийн хуулбарыг ирүүлнэ. - Хөлсөөр ажиллуулах гэрээ нь зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээний хугацаа, үнийн дүн болон бусад нөхцөлийг тодорхой тусгасан байна. - Гадаадын их дээд сургууль төгссөн болон мэргэжил дээшлүүлсэн бол дипломын хуулбар ирүүлэх 	№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил	Диплом, гэрчилгээний хуулбар ирүүлэх шаардлагатай эсэх	1	Ерөнхий инженер	1	3 болон түүнээс дээш жил.	Цахилгааны болон мэдээлэл технологийн чиглэлийн инженер	Диплом ирүүлэх шаардлагагүй	2	Мэдээлэл технологийн чиглэлийн инженер	1	2 болон түүнээс дээш жил	Мэдээлэл технологийн чиглэлийн инженер	Диплом ирүүлэх шаардлагагүй.	3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	1 болон түүнээс дээш жил	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан гэрчилгээтэй байна	Сургалтад хамрагдсан гэрчилгээ ирүүлнэ.	4	Ажил гүйцэтгэхэд шаардлагатай бусад инженер	2		Ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн ажиллах хүчин байна. Заавал байх шаардлагагүй.	Ажил гүйцэтгэхэд чиглэгдсэн мэргэжилтэй байх
№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн туршлага	Мэргэжил	Диплом, гэрчилгээний хуулбар ирүүлэх шаардлагатай эсэх																										
1	Ерөнхий инженер	1	3 болон түүнээс дээш жил.	Цахилгааны болон мэдээлэл технологийн чиглэлийн инженер	Диплом ирүүлэх шаардлагагүй																										
2	Мэдээлэл технологийн чиглэлийн инженер	1	2 болон түүнээс дээш жил	Мэдээлэл технологийн чиглэлийн инженер	Диплом ирүүлэх шаардлагагүй.																										
3	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	1 болон түүнээс дээш жил	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан гэрчилгээтэй байна	Сургалтад хамрагдсан гэрчилгээ ирүүлнэ.																										
4	Ажил гүйцэтгэхэд шаардлагатай бусад инженер	2		Ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн ажиллах хүчин байна. Заавал байх шаардлагагүй.	Ажил гүйцэтгэхэд чиглэгдсэн мэргэжилтэй байх																										

	<p>- Гүйцэтгэгч талаас томилогдсон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нь ажил гүйцэтгэхэд өдөр тутмын зааварчилгаа өгч байх, ажил гүйцэтгэх явцад гарсан эрсдлийг гүйцэтгэгч бүрэн хариуцах тухай мэдэгдэл ирүүлнэ.</p>
ТШЗ 19.2	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг: <i>Шаардана</i></p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын дэлгэрэнгүй танилцуулга. 2. Барааны үнийн задаргаа болон бараа нийлүүлэлтийн хуваарийг баталгаажуулан ирүүлнэ. 3. Нийлүүлэх барааны каталог, танилцуулга, зураг ирүүлэх 4. Захиалагч болон нийлүүлэгчийн техникийн тодорхойлолтыг харьцуулсан байдлаар дэлгэрэнгүй танилцуулга, фото зураг, каталог, хэмжээ зэргийг хүснэгтээр бэлтгэж баталгаажуулан ирүүлнэ. 5. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг хангаж байгааг нотолсон мэдэгдлийг баталгаажуулан ирүүлнэ. 6. Нийлүүлсэн барааг суурилуулах хуваарийг баталгаажуулан ирүүлнэ. Суурилуулж, шалгаж, зүгшрүүлж дуусах хугацаа нь гэрээ байгуулагдсан өдрөөс хойш хуанлийн 45 /дөчин тав/ хоног байна. 7. Оролцогч нь уг төндерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан техникийн нөхцөлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. 8. Нийлүүлэх хугацаанд гарсан барааны чанар, үйлдвэрлэгчээс шалтгаалсан аливаа хохирол, доголдлыг туслан гүйцэтгэгч болон гуравдагч этгээдээр дамжуулахгүйгээр шууд үйлдвэрлэгчтэй харилцаж, гарсан асуудлыг өөрийн зардлаар бүрэн шийдвэрлэхийг баталсан албан бичиг ирүүлнэ. 9. Нийлүүлсэн барааг тухайн цэгүүдэд хүргэх, суурилуулах, угсрал тээврийн болон бусад гарах зардлыг гүйцэтгэгч тал хариуцахад татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл ирүүлнэ. 10. 2022, 2023 оны аль нэг жилд ижил төстэй бараа нийлүүлсэн байна. Ижил төстэй гэдгийг “VPN, OPGW гэх мэт мэдээлэл дамжуулах сувгуудыг ашиглаж, технологийн мэдээллийг дамжуулах ажил гүйцэтгэсэн эсвэл мэдээлэл дамжуулах тоног төхөөрөмж нийлүүлж, суурилуулж” байсныг ойлгоно. 11. Бараа нийлүүлсэн гэрээ, гэрээ дүгнэсэн акт /протокол эсхүл дүгнэлт түүнтэй адилтгах баримт бичиг/-ын хуулбарыг ирүүлнэ. 12. Оролцогч нь IV бүлгийн Маягт 2 “Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл”, Маягт 3 “Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл”, Маягт 4 “Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл”-ийн дагуу мэдээллийг бэлтгэн ирүүлнэ. 13. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалтыг IV бүлгийн маягт 5-ын дагуу ирүүлнэ.

	<p>Жич: Дээрх баримт бичгүүдээс аль нэгийг нь ирүүлээгүй эсхүл шаардлага хангаагүй, цахимаар ирүүлсэн материал бүрэн гүйцэт уншигдахгүй, харагдахгүй, гаргацгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТШЗ 19.3	<p>Бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ шаардлагатай эсэх: Шаардахгүй</p> <p>Тусгай зөвшөөрөл: Шаардахгүй</p> <ul style="list-style-type: none"> - Оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэр (PDF)-т шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ. - Оролцогч нь III бүлгийн техникийн тодорхойлолт, бараа нийлүүлэлтийн хуваарийг бөглөж ирүүлэх. - Оролцогч нь IV бүлэгт заасан Маягт №1-5-ын дагуу мэдээллийг бөглөж ирүүлнэ. <p>ТӨХ-д шаардсан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТШЗ 21.1	<p>Санал болгож буй барааны нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээний талаарх мэдээлэл ирүүлэх эсэх: Тийм</p> <ul style="list-style-type: none"> - Захиалагчийн техникийн тодорхойлолтыг оролцогч этгээд дагаж мөрдөх ба техникийн тодорхойлолтын харьцуулсан хүснэгтийг бөглөж ирүүлнэ. - Тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгатай холбоотой зааварчилгаа, мэдээлэл ирүүлэх эсэх: Тийм Шаардлагатай тоног төхөөрөмжийн гарын авлага, зааварчилгаа, фото зургийг ирүүлнэ. - Нийлүүлэлтийн дараах засвар, үйлчилгээтэй холбоотой бусад шаардлага: Тийм Нийлүүлэх тоног төхөөрөмж нь шинэ, зориулалтынх байна гэдгийг нийлүүлэгч баталгаажуулна. Барааг хүлээж авснаас хойш 12 /арван хоёр/ сарын турш нийлүүлэгч нийлүүлсэн барааны алдаа, доголдол, гэмтэл, saatlyg хариуцан засварлах ба шаардлага хангаагүй тохиолдолд тоног төхөөрөмжийг 15 /арван тав/ хоногийн дотор сольж өгнө.
ТШЗ 22.2	Оролцогчийн санал болгосон тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: Тохируулахгүй тогтолцол байна
ТШЗ 22.3	Олон улсын худалдааны нөхцөлийг хэрэглэх эсэх: Тийм Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлнэ.
Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ	
ТШЗ 25.4	Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт: Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
ТШЗ 26.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Огноо: 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр Цаг: 09:00 цаг, минут



III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах барааны техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай барааг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардлагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөөт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгнө.
- Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн технологи зэргийг хангасан байх нөхцөлийг шаардана. Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайллан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.
- Бараа материалын, техникийн тодорхойлолтод аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсэн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

“VPN, OPGW СҮЛЖЭЭ ҮҮССЭН ДЭД СТАНЦУУДЫН ТООЛУУРЫН МЭДЭЭЛЛИЙГ ТУС СУВГААР ДАМЖУУЛАН АВАХ” АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Үндэслэл:

Тоолуурын нэгдсэн системийн дэд бүтэц нь APN сүлжээ буюу үүрэн холбооны дэд бүтцийг ашиглан мэдээлэл авдаг. Энэхүү сүлжээ нь алслагдсан цэгүүдээс мэдээлэл авахад тохиромжтой, хямд дэд бүтцийн шийдэл хэдий ч тасалдал ихтэй, хугацааны хоцролттой байдаг тул тоолуурын мэдээллийг шилэн кабелийн сүлжээгээр өндөр хурдаар, цагийн хязгаарлалтгүй авах шаардлага бий болсон.

ДҮТ ТӨХХК-тай шилэн кабелийн болон VPN сүлжээ үүссэн дэд станцуудын тоолууруудын мэдээллийг тус сувгаар дамжуулах боломжийг бүрдүүлэх, тоолуурын мэдээлэл дамжуулах гаралтын интерфэйстэй холбогдож ажиллах боломжтой мэдээлэл дамжуулах хувиргуур төхөөрөмж суурилуулах, үүссэн дэд бүтцийн сүлжээний тоног төхөөрөмжүүдэд тохиргоо хийх, тоолуурын нэгдсэн системийн үндсэн программ хангамжид (АльфаЦентр) тохиргоо хийх ажлууд хийгдэнэ.

Байршил:

1. ЦДУС ТӨХК-н 220/110/35/6 кВ-н Чойр дэд станц
2. ЦДУС ТӨХК-н 110/6 кВ-н Хот дэд станц
3. ЦДУС ТӨХК-н 110/6 кВ-н Төв дэд станцууд хамарагдана.

Техникийн шаардлага:

№	Төрөл	Тоног төхөөрөмж, ажил үйлчилгээ	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Үзүүлэлт
1	Төхөөрөмж	Хөрвүүлэгч төхөөрөмж Serial ethernet RS485/RS232 to Ethernet	ш	4	2-port device server with 1 RS-232 port and 1 RS-422/485 port, 0 to 55°C operating temperature. Configuration Options: Windows Utility, Serial Console, Telnet Console, Web Console (HTTP). Input Voltage: 12 to 48 VDC. MOXA прортой дүйцэхүйц (шинэ)
2		Сүлжээ зохицуулагч төхөөрөмж	ш	1	Сүлжээ зохицуулагч төхөөрөмж: Mikrotik RB1100AHx4 Ethernet Router, 13xGigabit Ethernet, Quad Core 1.4 GHz CPU, 1GB RAM. Mikrotik RB1100AHx4-той дүйцэхүйц (шинэ)
3		Сүлжээ салаалагч төхөөрөмж	ш	2	Порт: 5, Мэдээлэл дамжуулах хурд: 100/1000Mbps, тэжээл: DC 12-48V, -30°~+65° ажиллах боломжтой байх.
4		Шилэн кабелийн хөрвүүлэгч	хос	2	Шилэн кабелийн хөрвүүлэгч төхөөрөмж, 20-25км зайд мэдээлэл дамжуулах боломжтой. Мэдээлэл дамжуулах хурд: 100/1000Mbps. Оптик порт нь SC эсвэл SFP модулийн оролттой гэсэн сонголтуудтай. Auto-negotiation, UTP full/half duplex горимыг DIP свичээр өөрчлөх боломжтой.

5	Кабель, утас	Сигналын кабель	м	350	Уян зэс кабель, дамжуулагч нь олон тооны жижиг зэс салаанаас бүрдэх, резин тусгаарлагч болон резин бүрхэвчтэй. Кабелийн дотоод судал нь өөр өөр өнгөөр ялгарсан. Судлын тоо, үндсэн судлын оттолол, мм2: 2x1x0.75
6		Сүлжээний кабель	м	100	UTP, CAT5E, RJ45, Кабелийн голч: 4P*0.5±0.01mm, Материал: Зэс,
7		Гадуур татах зориулалттай сүлжээний кабель	м	300	Outdoor SFTP, CAT5E, RJ45, Кабелийн голч: 4P*0.5±0.01mm, Материал: Зэс,
8		Жампер кабель	ш	4	FC-SC Fiber Patch Cord, Single mode, Simplex 5m
9	Бусад дагалдах тоноглол	Сүлжээний толгой	ш	30	CAT5E, RJ45
10		Кабелийн хар хоолой	м	300	25мм диаметртэй
11		Кабель, утас багцлагч 140мм*5,75мм хэмжээтэй, 500ш	уут	1	140мм*5,75мм хэмжээтэй, нэг уут: 450-500ш
12		Шулуун төгсгөвч	уут	1	E1508 1.5мм, нэг уут: 200ш
13		Кабелийн бирк, хаяглалт	уут	1	3.5мм*2.5мм, нүхтэй, нэг уут: 50ш
14		Өгөгдөл оруулах, холболтыг үүсгэх, зүгшрүүлэх, туршилт тохируулга	багц	1	Өгөгдөл оруулах: Тоолуурын нэгдсэн системийн үндсэн программ хангамжид шинээр холбогдсон цэгүүдийн утга оруулах, өгөгдөл өөрчлөлт хийх, программ хангамжийн талд хийгдэх ажил гэж ойлгоно. Холболтыг байгуулах, зүгшрүүлэх: Шилэн кабелийн сүлжээ үүссэн дэд станцуудад суурилагдсан сүлжээний тоног төхөөрөмжүүдэд тохиргоо хийх, шинээр үүсгэж мэдээлэл дамжуулах тоолуурын нэгдсэн системийн сүлжээг бусад технологийн сүлжээнээс тусад нь үүсгэж, тохиргоо хийнэ. Тоолуурын мэдээлэл дамжуулах хөрвүүлэгч төхөөрөмж суурилуулах, тухайн цэгт дэд бүтэц үүсгэх ажил хийнэ. Туршилт тохируулга: Шинээр холбогдсон цэгүүдийн тоолуурын мэдээлэл тасралтгүй бүрэн, хугацааны хоцрогдолгуй ирэхэд туршилт, тохируулга хийх.
15	Ажил гүйцэтгэл	Машин механизм, тээврийн зардал	багц	1	Ажил гүйцэтгэх үеийн ажиллах хүчиний болон тоног төхөөрөмжийн тээвэрлэлтэд зориулагдсан зардал гэж ойлгоно.
16		Ажиллах хүчиний зардал	багц	1	Ажил гүйцэтгэх үеийн томилолт, ажиллах хүчиний зардал гэж ойлгоно.

Баталгаат хугацаа:

Тоног төхөөрөмж, ажил гүйцэтгэлд 12 (арван хоёр) сар байна.

Хийгдэх ажлууд:



- Холбогдох заавар, журмын дагуу ажил гүйцэтгэлийн цэгт нэвтэрч тоног төхөөрөмж суурилуулах, холболт, тохиргоо хийх.
- Тоолуурын нэгдсэн системийн үндсэн программ хангамжид шинээр холбогдсон цэгүүдийн утга оруулах, өгөгдөл өөрчлөлт, шинэчлэлт хийх.
- OPGW болон VPN сүлжээ (үүрэн холбооны байнгын бус холболт) үүссэн дэд станцуудад суурилагдсан сүлжээний тоног төхөөрөмжүүдэд тохиргоо хийх, шинээр үүсгэсэн мэдээлэл дамжуулах сүлжээг бусад технологийн сүлжээнээс тусад нь үүсгэж, тохиргоо хийнэ. Тоолуурын мэдээлэл дамжуулах хөрвүүлэгч төхөөрөмж суурилуулах, тухайн цэгт дэд бүтэц үүсгэх.
- Шинээр холбогдсон цэгүүдийн тоолуурын мэдээлэл тасралтгүй бүрэн, хугацааны хоцрогдолгүй ирэхэд туршилт, тохируулга хийх.
- Шинээр суурилагдсан тоног төхөөрөмжүүд, мэдээлэл солилцох кабелиудад хаягжилтыг ойлгомжтой бүрэн, холбогдох стандартын дагуу хийх.
- Шинээр суурилагдах мэдээлэл дамжуулах үүрэг бүхий хөрвүүлэгч төхөөрөмжийн тохиргоог тоолуурын нэгдсэн системийн ашиглаж буй сүлжээний бүтцэд тааруулж тохиргоо хийх.
- Ажил гүйцэтгэх хийгдэх цэгүүдэд хийгдсэн шинэ холболт, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг илтгэсэн ажил гүйцэтгэлийг зургийг стандартын дагуу боловсруулах.
- Ажил гүйцэтгэлийн явцад захиалагчийг хяналт хийх боломжоор бүрэн хангах.



БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

[Гендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө. Шаардлагатай гэж үзээл оротгоч баргааг нэг буруцэн "Бараа нийлүүлэлтийн хувадарьт тусганы"]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, туh	Барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэлтэх хугацаа		
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэлчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)	
					5	6	7
1	2	3	4				
1	VPN, OPGW сүлжээ үүссэн дэд станцуудын тоолуурлын мэдээллийг тус суулгыар дамжуулсан авах	1	Базы	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн Өргөн чөлөө, Засгийн газрын 14 дүгээр байр. 4 дүгээр давхар, Диспетчерийн үндэсний төв ТӨХХК	Гэрээ байгуулснаас хойши 45 хоногийн дотор	[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]	
2							
3							



IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Захиалагч энэ бүлэгт оролцогчийн бөглөх шаардлагатай бүх маягтыг тусгана.

Маягтын жагсаалт:

Маягт 1: Тендер илгээх маягт.....	22
Маягт 2: Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл	23
Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл.....	23
Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл.....	23
Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт.....	23

Маягт 1: Тендер илгээх маягт

[Огноо]

Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан VPN, OPGW сүлжээ үүссэн дэд станцуудын тоолуурын мэдээллийг тус сувгаар дамжуулан авах, ДҮТ/2024020003 дугаартай тендер шалгаруулалтын үнийн санал дуудах ажиллагаанд эцсийн санал болгосон үнээр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаarahгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.1. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 3.1. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
 - 4.1. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаarahгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээнээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна¹
5. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
6. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын догондолгүй болохыг баталж байна.
7. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

Баталгаажуулсан: Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг мэдээлэл:

Маягт 2: Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 3: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 5: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь захиалагч, гүйцэтгэгч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно.

Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох бараа худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол ГТН-ийн холбогдох заалтад тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан өөрчлөлт оруулан ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөхгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, too хэмжээ зэрэгт нийцүүлэн тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР	
Тодорхойлолт	<p>1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:</p> <p>1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;</p> <p>1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;</p> <p>1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;</p> <p>1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;</p> <p>1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;</p> <p>1.1.6. “Хууль” гэж Териин болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;</p> <p>1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиорлцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.</p> <p>1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;</p> <p>1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;</p> <p>1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;</p> <p>1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;</p> <p>1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;</p> <p>1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;</p> <p>1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Териин эрх бүхий байгууллага, албан тушаалтны</p>

	үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориотой өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.
Гэрээний тайлбар	<p>1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:</p> <p>1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.</p> <p>1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.</p> <p>1.2.3. Зүйл, заалт, уг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлахад бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.</p> <p>1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсэн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.</p> <p>1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулнаас хувиуд нь хоорондоо зөрчилдсэн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.</p>
ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ	
Бараа нийлүүлэх	<p>2.1. Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй</p> <p>2.2. Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Төндерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна</p> <p>2.3. ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.</p> <p>2.4. Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг үүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.</p>
Бараа нийлүүлэх газар	2.5. Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах	<p>2.6. Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.</p> <p>2.7. Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:</p> <p>2.7.1. Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;</p> <p>2.7.2. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.</p> <p>2.8. Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.</p> <p>2.9. ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.</p>
Барааг хүлээлгэн өгөх	2.10. Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.

	2.11. Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.
Барааны гарал үүслийн улс	2.12. Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна. 2.13. Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.
Баглаа боодол	2.14. Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хийнэ. 2.15. Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно. 2.16. Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрднө.
Худалдааны нөхцөл	2.17. Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана. 2.18. ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарыт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
ГУРАВ. ЗАХИАЛАГЧ	
Барааг хүлээн авах	3.1. Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
Шалгалт, туршилт	3.2. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.
	3.3. Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ. 3.4. ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна. 3.5. Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй. 3.6. Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.
Гэрээний үнэ	3.7. Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана. 3.8. Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.
Төлбөр төлөх	3.9. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.

	<p>3.10. Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.</p> <p>3.11. Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.</p> <p>3.12. Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.</p> <p>3.13. ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p> <p>3.14. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.</p> <p>3.15. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.</p>
--	---

ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА

Захиалагчийн хүлээх эрсдэл	<p>4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;</p> <p>4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.</p>
Даатгал	<p>4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.</p>
Доголдол	<p>4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.</p> <p>4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.</p> <p>4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид өгнө.</p> <p>4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.</p> <p>4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.</p> <p>4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.</p> <p>4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.</p>
Чанарын баталгаа	<p>4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.</p>

	<p>4.11.ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.</p> <p>4.12.Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.</p> <p>4.13.ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>4.14.Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнэ.</p> <p>4.15.ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.</p> <p>4.16.ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p>
Алданги	<p>4.17.Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.</p> <p>4.18.Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.</p>
Оюуны өмчийн эрх зөрчих	<p>4.19.Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p>
Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нэхцэл байдал	<p>4.20.Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нэхцэл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>4.21.Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p>
	<p>4.22.Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>4.23.Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.</p>
Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа	<p>4.24.Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нэгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.</p> <p>4.25.Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэспэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.</p>

ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл	<p>5.1.Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:</p> <p>5.1.1.Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;</p> <p>5.1.2.Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;</p> <p>5.1.3.Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.</p> <p>5.1.4.Нийлүүлэгч өөрийн тендериин давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй.</p> <p>5.2.Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.</p> <p>5.3.Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.</p> <p>5.4.Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.</p>
Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл	<p>5.5.Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.</p>

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

Төлөөлөгч	<p>6.1.Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>6.2.Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.</p> <p>6.3.Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.4.Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусад шилжүүлэхийг хориглоно.</p>
Туслан гүйцэтгэгч	<p>6.5.Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>6.6.Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтруулэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.</p>
Нууцлал	<p>6.7.Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.</p> <p>6.8.Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.</p>

Мэдэгдэл	<p>6.9.Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.</p> <p>6.10.Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.11.Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.</p> <p>6.12.Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:</p> <p>6.12.1.баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;</p> <p>6.12.2.биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.</p> <p>6.13.Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.</p> <p>6.14.ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.</p>
Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах	<p>6.15.Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:</p> <p>6.15.1.ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;</p> <p>6.15.2.үнийн тохируулга хийсэн.</p>
	<p>6.16.Гэрээний нэмэлт, өөрчлөлтэд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.</p> <p>6.17.ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.</p>
Маргаан шийдвэрлэх	<p>6.18.Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.</p>
	<p>6.19.Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.</p>

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.5.	<p>Бараа нийлүүлэх газар: Техникийн шаардлагад тусгасан байршил тус бүрт, захиалагчийн санаалаар /ЦДҮС ТӨХК-ийн 220/110/35/6 кВ-н Чойр дэд станц, 110/6 кВ-н Хот дэд станц, 110/6 кВ-н Төв дэд станц/</p>
ГЕН 2.6.	Бараа нийлүүлэх хугацаа: Гэрээ байгуулагднаас хойш 45 хоногийн дотор
ГЕН 2.10.	<p>Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:</p> <ul style="list-style-type: none"> - Бараа материал суурилуулсан талаарх холбогдох материалууд, фото зураг - Нийлүүлсэн барааг угсарч суурилуулсан талаарх тайлан, фото зураг - Захиалагч, нийлүүлэгч талын төлөөллийг оролцуулсан “Ажил хүлээлцэх акт”
ГЕН 2.14.	<p>Баглаа, боодол:</p> <p>Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна. Барааны тээвэрлэлтийн бүрэн бүтэн байдлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.</p>
ГЕН 2.17.	<p>Худалдааны нөхцөл:</p> <p>Incoterms 2020 Delivery Duty Paid (DDP) нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хувьарыг дурдсан газарт хүргүүлнэ.</p>
ГЕН 3.9.	<p>Төлбөр төлөх хугацаа: Урьдчилгаа төлбөр: Олгохгүй Гэрээ дүгнэж, ажил хүлээлцэх комиссын акт баталгаажсанаас хойш 30 хоногт гүйцэтгэгчийн нэхэмжлэх, захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн гэрээний үнийн 95 /ерэн тав/ хувьтай тэнцэх дунг төлнө.</p>
ГЕН 4.2.	<p>Даатгал: Тээвэрлэлтийн эцсийн цэг хүртэлх даатгалыг нийлүүлэгч бүрэн хариуцна.</p>
ГЕН 4.10.	<p>Баталгаат хугацаа: Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн байна. Нийлүүлэх сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж нь шинэ, зориулалтынх байна гэдгийг нийлүүлэгч баталгаажуулна. Барааг хүлээж авснаас хойш 12 /арван хоёр/ сарын турш нийлүүлэгч нийлүүлсэн барааны алдаа, доголдол, гэмтэл, saatlyig хариуцан засварлах ба шаардлага хангаагүй тохиолдолд сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийг 15 /арван тав/ хоногийн дотор сольж өгнө.</p>
ГЕН 4.11	<p>Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: Шаардана Чанарын баталгаа гэрээний үнийн дүнгийн 5 /тав/ хувьтай тэнцэх дүнгээр тооцогдох ба тоног төхөөрөмжийн баталгаат засварын хугацаатай адил буюу 12 /арван хоёр/ сарын хугацаатай байна.</p>
ГЕН 4.17.	<p>Нийлүүлэгчийн төлөх алданги: Алданги оногдуулах хувь: Тийм Алданги ногдуулах хэмжээ: Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.05 /тэг зууны тав/ хувь байна. Алдангийн нийт дүн: Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ гэрээний үнийн 10 /арав/ хувьас хэтрэхгүй байна.</p>
ГЕН 4.18.	Захиалагчийн төлөх алданги:

Алданги оногдуулах хувь: ***Тийм***

Алданги ногдуулах хэмжээ: Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн **0.05 /тэг зууны тав/ хувь** байна.

Алдангийн нийт дүн: Нийт ногдуулах алдангийн дээд хэмжээ гэрээний үнийн **10 /арав/ хувисас** хэтрэхгүй байна.

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

VPN, OPGW сүлжээ үүссэн дэд станцуудын тоолуурын
мэдээллийг тус сувгаар дамжуулан авах гэрээ.

Дугаар № ДҮТ/20240202003

Улаанбаатар хот

Нэг талаас **Диспетчерийн үндэсний төв ТӨХХК** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Техникийн тодорхойлолт;
 - 3.6. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024 оны 02 дугаар сарын 26**

Тендер шалгаруулалтын төрөл: **Бараа**

Тендер шалгаруулалтын нэр: **VPN, OPGW сүлжээ үүссэн дэд
станцуудын тоолуурын мэдээллийг
тус сувгаар дамжуулан авах**

Тендер шалгаруулалтын дугаар: **ДҮТ/20240202003**

Нийт төсөвт өртөг: **37,165,030 төгрөг**

Тендер шалгаруулалтын арга: **Харьцуулалт**

1. **Диспетчерийн үндэсний төв ТӨХХК** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **Үгүй**
3. Унийн санал дуудах ажиллагаанд шаардлагатай оролцогчийн тоо: **1-ээс багагүй**
4. Унийн санал дуудах ажиллагаанд бүртгүүлэх журам: **Унийн санал дуудах журам**
5. Унийн санал дуудах ажиллагааг **2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр 09:30** минутад эхлүүлж, **2 цагийн** хугацаанд зохион байгуулна.
6. Тендерийг 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр 09:00 цаг, минутаас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг 2024 оны 03 дугаар сарын 06-ний өдөр 09:30 цаг, минутад нээнэ.
7. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **Зөвшөөрөхгүй**
8. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **Эрхгүй**
9. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
10. Оролцог цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

**Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын 14-р байр, 5
дахар, 514 тоот, М.Энхбаясгалан, 70041371-289**

